

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Н.НАРАНБААТАР

.... оны ... дугаар сарын ...

ТУУЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баримт бичгийн үйлчлэх хугацаа: 2024 – 2028 он / 4 жил /

ТУУЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Э.АЛТНАА

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. АЛСЫН ХАРАА	5
ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	5
ДӨРӨВ. УРИА	5
ТАВ. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	5
ЗУРГАА. ОРЧИНЫ ШИНЖИЛГЭЭ	9
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	10
НАЙМ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ	12
ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	14

ТУУЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2024-2028 он)

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Туул тосгоны эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад, дотоод сургалт, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд хүн амын эрүүл мэндийн байдал, өвчлөлд хүргэх эрсдэлт хүчин зүйлс, өвчнийг үүсгэж буй шалтгаан, үр дагаврыг судлах, тандах, хянах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг хариу арга хэмжээг төлөвлөх, явуулах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зэрэг эрүүл мэндийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг дүүрэг, хороо харьяаллын түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Анх 1964 оны 08 дугаар сарын 13-нд “ АЖИЛЧНЫ РАЙОНЫ 14-Р ХОРООНЫ ЭМНЭЛЭГ” нэртэйгээр байгуулагдсан цагаас эхлэн амбулатори, хэвтэн эмчлүүлэгч, эмчилгээ, оношилгоо, урьдчилан сэргийлэлт, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэл, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг ариун цэвэр, эрүүл ахуй, халдвар судлалын чиглэлээр Нийслэлийн Засаг даргын 2003 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 283 дугаар захирамжаар “ТУУЛ ТОСГОНЫ ХҮН ЭМНЭЛЭГ” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж, байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны үр дүнг сайжруулан үндэсний хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор 2015 онд “ТУУЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ” болгон өргөжүүлсэн байдаг.

Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлохдоо 4.2.2-т “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах” гэж, мөн хуулийн 13.2-т “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна” гэж тус тус заасан.

Монгол Улсын хэмжээнд зүрх судасны тогтолцооны өвчин, хорт хавдар, амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болоод зогсохгүй артерийн даралт ихсэлтийн тархалтаар Номхон далайн баруун бүсийн 37 орныг тэргүүлсэн хэвээр байна. Хүн амын дундаж нас баралтын 71% нь халдварт бус өвчний шалтгаантай, үүнээс 33% нь харьцангуй сэргийлж болох өвчлөл, нас баралт эзэлж байгаа бол халдварт бус өвчин, осол гэмтэл нь бүтээлч насныханд өвчлөл, нас баралтын гол шалтгаан болсон хэвээр байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд цогц байдлаар хөгжүүлж, урьдчилан сэргийлэх боломжтой өвчин эмгэгийн тархалт, өвчлөлийг бууруулах нь нэн тэргүүний зорилт болсон энэ цаг үед нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг баримтлан хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг өвчин эмгэгийг эрт илрүүлэх, төгс эмчлэхэд төдийгүй, эрүүлжүүлэх, эрүүл зүй зохистой аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхтэй оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө нь байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаанууд идэвхтэй явагдаж, хууль эрх зүй, зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх чиглэлд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа ажлын хэсгийн гишүүдийг сургалтад хамруулж, тус төвийн алба, нэгжүүдийн санал, мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг авч, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалд нийцүүлэн үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдал, орчны шинжилгээ, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, хяналт, үнэлгээ гэсэн арга зүйн дарааллын дагуу гүйцэтгэсэн болно.

Энэхүү стратеги төлөвлөгөөг Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль түүний удирдлагын тухай хууль, Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал” зэргийг үндэслэн энэхүү төлөвлөгөөг боловсруулсан.

Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал болон холбогдох бусад чиглэлээр судлаачдын хийсэн судалгааны үр дүн, дэлхий нийтийн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан, Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого зэрэг эрх зүйн баримт бичгийг үндэслэл болгон Туул Тосгон эрүүл мэндийн төвийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчин, төсөв, санхүү, техник хэрэгсэл, барилга байгууламж, хүний нөөцийн байдалд дүн шинжилгээ хийж, байгууллагын 2026-2029 онд хөгжүүлэх стратегийн зорилго, зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох чухал ач холбогдолтой болно.

Туул тосгон эрүүл мэндийн төвийн бүтэц, үндсэн чиг үүргийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/33 дугаар тушаалд тодорхойлсны дагуу дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Дүүрэг хорооны хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж болон эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг хугацаа алдахгүй үзүүлэх.
- Эрүүл мэндийн бусад байгууллагатай мэргэжил, арга зүйгээр хамтарч ажиллах.
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандан судалж үр дүнг тооцох;
- Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох;
- Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох;

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн нийгмийн эрүүл мэндийн чиглэлийг дүүрэг, хорооны түвшинд хэрэгжүүлэн мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах;
- Хүний эрүүл мэндэд нөлөөлж буй нийгэм, зан үйл, хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг тогтоох, үнэлэх чиглэлээр судалгаа хийх, тандах, хянах судалгааны үр дүнг нийтэд болон холбогдох байгууллагад мэдээлэх, ухуулан сурталчлах, практикт нэвтрүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, мэдээлэх, хянах, салбарын байгууллагуудын оролцоог дэмжих, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг тасралтгүй зохион байгуулах;
- Бусад салбарын бодлого, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах ажлыг зохион байгуулах, мэдээ зөвлөмжөөр хангах;
- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвтэй халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр ажилладаг мэргэжлийн төвүүдэдтэй хамтарч ажиллах;

Стратеги төлөвлөгөө нь төрөөс баримтлах бодлогын баримт бичигт дэвшүүлсэн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд хүн амыг эрүүл амьдралын зөв дадалд сургах, иргэдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар иргэдийн эрүүл мэндийг дэмжих, улмаар улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилтыг хангахад чиглэгдэнэ.

Энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр байгууллагын хөгжлийн ирээдүйн чиг хандлага, тэргүүлэх чиглэл тодорхой болж, өөрчлөгдөн буй гадаад орчны нөхцөл байдалд үйл ажиллагаагаа нийцүүлэх боломж бүрдэж, удирдлага, зохион байгуулалтаа тасралтгүй сайжруулж, ажилтнуудын ур чадвар, харилцаа хандлага, мэдлэг дадал хөгжиж, гадаад, дотоод харилцаа хамтын ажиллагаа өргөжин тэлж, байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй амжилттай явагдах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

ХОЁР. АЛСЫН ХАРАА

Нийслэлийн жишиг тосгоны эрүүл мэндийн төв болох

ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай тасралтгүй хүргэж иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал мэдлэгтэй иргэдийн тоог нэмэгдүүлж хорооны иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

ДӨРӨВ. УРИА

Эрүүл мэнд - Эрхэм баян

ТАВ. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатын шинжилгээг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн актаар тус төвд хуулиар олгосон чиг үүргийг хамруулж тодорхойлсон. Үүнд:

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо – 66		Монгол Улсын хууль тогтоомж
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо - 59	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Үндсэн хууль 2. Төсвийн тухай хууль 3. Төрийн албаны тухай хууль 4. Хөдөлмөрийн тухай хууль 5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 6. Авлигын эсрэг хууль 7. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 8. Гамшгаас хамгаалах тухай хууль 9. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 10. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 11. Хүнсний тухай хууль 12. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль 13. Зар сурталчилгааны тухай хууль 14. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 15. Хог хаягдлын тухай хууль 16. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 17. Иргэний хууль 18. Зөрчлийн тухай хууль 19. Өрсөлдөөний тухай хууль 20. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 21. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 22. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 23. Төрийн хяналт шалгалтын тухай хууль 24. Тамхины хяналтын тухай хууль 25. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 26. Мансууруулах эм сэтгэц нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль 27. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль 28. Аудитын тухай хууль 29. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 30. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 31. Байгууллагын нууцын тухай хууль 32. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль 33. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 34. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

		<p>35. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль</p> <p>36. Дархлаажуулалтын тухай хууль</p> <p>37. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль</p> <p>38. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль</p> <p>39. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль</p> <p>40. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль</p> <p>41. Эрүүгийн хууль</p> <p>42. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль</p> <p>43. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль</p> <p>44. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль</p> <p>45. Улсын бүртгэлийн ерөнхий хууль</p> <p>46. Нийгмийн халамжийн тухай хууль</p> <p>47. Ахмад настны тухай хууль</p> <p>48. Статистикийн тухай хууль</p> <p>49. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль</p> <p>50. Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль</p> <p>51. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль</p> <p>52. Галын аюулгүй байдлын тухай хууль</p> <p>53. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль</p> <p>54. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль</p> <p>55. Онц байдлын тухай хууль</p> <p>56. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль</p> <p>57. Биеийн тамир, спортын тухай хууль</p> <p>58. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль</p> <p>59. Агаарын тухай хууль</p>
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо - 7	<p>1. Эрүүл мэндийн тухай хууль</p> <p>2. Нийгмийн эрүүл мэндийн тухай</p> <p>3. Эрүүл ахуйн тухай хууль</p> <p>4. Усны тухай хууль</p> <p>5. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль</p> <p>6. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль</p> <p>7. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль</p>
Ерөнхий чиг үүрэг-1: Эмнэлгийн болон Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1.1: Хүн амын эрүүл мэндийг дэмжих,	Иргэдэд эрүүл орчинд амьдрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа	ЭМЯ, НЭМГ, ЭМХТ, дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд
	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагаа	

хамгаалах, сурталчлах, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээ авах	Эрүүл мэндийн дэмжих үйл ажиллагаа	ЭМЯ, НЭМГ, УОК, ОБЕГ, ХӨСҮТ, Нийслэл, дүүргийн Нэгдсэн шуурхай штаб
	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тандах үйл ажиллагаа	
	Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа	
	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	
	Гэнэтийн аюул, байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдал	
Ерөнхий чиг үүрэг-2: Дотоод, гадаад сургалт, сурталчилгаа		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-2.1: Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн тандалт судалгаа	Тус эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүдийн харилцаа хандлага, мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулж, байгууллагын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх	ЭМЯ, НЭМГ, ЭМХТ
	Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийн тандалт судалгаа	ЭМЯ, НЭМГ, дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд, тандалтын баг
Ерөнхий чиг үүрэг-3: Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах		
ҮЧҮ-3.1: Харилцаа хандлага, мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулж, байгууллагын хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх	Хүний нөөцийн хүртээмжтэй байдал, мэргэжил дээшлүүлэх гадаад дотоодын сургалт	ЭМЯ, НЭМГ, ЭМХТ, хамтрагч байгууллагууд
Ерөнхий чиг үүрэг-4: Санхүүгийн тогтвортой эх үүсвэр		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-4.1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн тогтвортой эх үүсвэр	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт	ЭМЯ, ДЭМБ, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн

ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

ДОТООД ОРЧИН	
<p style="text-align: center;">ДАВУУ ТАЛ:</p> <ul style="list-style-type: none">❖ Байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг хамт олны хурлаар хэлэлцүүлж, зөвшилцсөний үндсэн дээр тодорхойлсон;❖ Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол явуулж хэвшсэн;❖ Дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх бүрэн боломжтой;❖ Нийт ажилтнуудын дийлэнх нь нарийн мэргэжил эзэмшсэн. одооны байдлаар яаралтай, лаборатори, эмэгтэйчүүд, уламжлал, шүдний нарийн мэргэжлийн эмч нар тогтвор суурьшилтай ажиллах мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн;❖ Сүүлийн үеийн стандартаар баригдсан доороо зорьтой 4 давхар шинэ эмнэлгийг 2017 оноос 2021 онд 2 тэрбум 700 сая төгрөгөөс 3 тэрбум орчим санхүүжилтийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас, хөрөнгө оруулалт хийж 2020 онд ашиглалтад орсон.❖ ЭМЯ, ДЭМБ болон холбогдох дээд шатны байгууллагуудаас түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашинаар хангаж тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.❖ Байгууллагын түргэн тусламжийн автомашины дулаан зогсоол ашиглалтад оруулсан.❖ Ажилчдад зориулсан амралтын өрөө, чийрэгжүүлэлт болон усанд орох өрөө, хүүхдүүдийн амарч хичээл хийх зориулалт бүхий өрөөг тохижуулсан.❖ Засгийн газрын тогтоолын дагуу ажилчдад орон нутгийн нэмэгдлийг бүрэн олгодог.❖ Ажилчдын унаа хоолны мөнгийг өмнөх жилүүдээс 5 дахин	<p style="text-align: center;">СУЛ ТАЛ:</p> <ul style="list-style-type: none">❖ Улаанбаатар хотоос 47-50 км орчим алслагдсан бүсэд оршдог;❖ Улаанбаатар хотоос ажилладаг ажилчдын байрлаж ажиллах байргүй;❖ Техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал шинэ технологи нэвтрүүлэхэд хангалтгүй;❖ Байгууллагын үйл ажиллагаанд нэн шаардлагатай мэргэшсэн боловсон хүчний тоо хязгаарлагдмал, олдоц муу;❖ Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн нөөц, бололцоо хязгаарлагдмал;❖ Эмнэлгийн барилга нь нийслэлийн төвийн инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй.❖ Эрчим хүчний нөөц эх үүсвэргүй бөгөөд жижиг оврын цахилгаан үүсгэвэр ашигладаг.

нэмэгдүүлж нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.	
ГАДААД ОРЧИН	
БОЛОМЖ	ЭРСДЭЛ
<ul style="list-style-type: none"> • “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тусгагдсан; • Нийслэл эрүүл мэндийн газраар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, үр дүнгийн гэрээ байгуулан гүйцэтгэлийг тогтмол тайлагнаж ажилладаг; • Хан-Уул дүүрэгт байрлах лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй хамтран ажиллах; • Лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй хамтран нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэж, ажиллуулах; 	<ul style="list-style-type: none"> • Удамшлын эмгэг, зүрх судас, мэдрэлийн өвчин, хорт хавдар зэргийг эрт илрүүлэх тогтолцоо бүрдээгүй; • Тосгоны нутаг дэвсгэрт карьер, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотойгоор тоосжилт их хэмжээгээр үүсэж хүн амын дунд амьсгал, зүрх судасны өвчлөл нэмэгдсэн; • Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хөдөлгөх, үйл ажиллагааг сурталчлах сургалт, дадлага хэвшлийн үйл ажиллагааг явуулахад санхүүжилт хангалтгүй; • Хүн амын эрүүл мэндийн боловсрол хангалтгүй; • Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол, хүний амь насанд аюул учруулах халдварт өвчний үед үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хангалтгүй;

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Туул Тосгон Эрүүл мэндийн төвийн стратегийн зорилго нь нийтийн санаачилга, оролцоонд тулгуурлаж, шинжлэх ухааны нотолгоонд суурилсан нийгмийн эрүүл мэндийн тусламж болон эмнэлгийн тусламж үйлчилгээ бодлого, менежментийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхэд оршино.

Шинжлэх ухааны ололт, амжилтыг ашиглан хүн амын эрүүл мэнд, иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, иргэдэд эмчилгээ, оношилгоо, урьдчилан сэргийлэх үзлэг, гэрийн идэвхтэй эргэлтийг тогтворжуулж, эрүүл урт наслалтыг дэмжин, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог дэмжих, эндэгдлийг бууруулах, дундаж наслалтыг уртасгах чиглэлээр үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй хүргэнэ.

Стратегийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

ЗОРИЛГО: СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулна.

- Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн мэдээ мэдээлэл сургалт сурталчилгааг танхим болон цахим хэлбэрээр явуулах
- Зорилт 2. Халдварт бус өвчин эмгэг тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, эмчлэх, хяналтын тогтолцоог сайжруулах
- Зорилт 3. Хүрээлэн буй орчноос үүдэлтэй өвчин эмгэг сэтгэц зан үйлийг тандах, өвлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох
- Зорилт 4. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах тогтолцоог бүрдүүлж чадавхжуулах
- Зорилт 5. Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн эмэгтэйчүүдэд чиглэсэн гэр бүл төлөвлөлтийн боловсрол олгох, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна.

- Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг тосгоны хүн амын эрэлт, хэрэгцээтэй уялдуулан шинэчлэн зохион байгуулах,
- Зорилт-2. Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна;
- Зорилт-3. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх;
- Зорилт-4. Эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулж, эмэн эмчилгээний хорооны үйл ажиллагаанд хяналт тавих.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэн, нийгмийн баталгааг хангана.

- Зорилт-1. Байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, чадавхжуулах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Зорилт-2. Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, эрүүл мэндийн ажилтныг ажлын байрны эрсдэлээс хамгаалах;
- Зорилт-3. Эмнэлгийн мэргэжилтний тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. Байгууллагын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг оновчтой, үр дүнтэй болгоно.

- Зорилт-1. Эмнэлгийн санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлэх, тогтвортой байдлыг хангах
- Зорилт-2. Эрүүл мэндийн төвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг хийж, нөөцийг оновчтой, үр дүнтэй хуваарилах замаар барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, автомашины хангамжийг стандартын шаардлагад нийцүүлэн үе шаттай хүргэх

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5. Байгууллагын мэдээллийн тогтолцоог цахимжуулах ажлыг хөгжүүлж, нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллийг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана.

- Зорилт-1. Орчин үеийн технологийн шийдэлд тулгуурлан эрүүл мэндийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, иргэн төвтэй цахим үйлчилгээг чанаржуулан хөгжүүлэх

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 6. Байгууллагын тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт-1. Зорилго алсын хараа, стратегийг сайжруулах

Зорилт-2. Байгууллагын соёл ба манлайллыг хэрэгжүүлэх

Туул тосгоны эрүүл мэндийн төвийн мандатад тулгуурласан дээрх зорилтууд нь тус төвийн эрхэм зорилгыг хэрэгжүүлж, алсын хараанд хүрэхэд чиглэгдэнэ. Үүний тулд үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримталж ажиллахаар тусгасан болно.

НАЙМ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Төвийн ажилтнууд нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана.
Үүнд:

T- Төрийн үйлчилгээний албан хаагчийн өндөр ёс зүй, харьцаа хандлагатай ажиллах.

T- Түмний сэтгэлд бодитоор хүрч ажиллах.

Э- Энэрэнгүй хүнлэг, сэтгэлээр үйлчлүүлэгчдэдээ хандах.

M- Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай байх.

T- Түргэн шуурхай, чанартай үйлчилгээг иргэдэд үзүүлэх.

- Хариуцлага, ёс зүйтэй. Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлагаа дээдлэн, ёс зүй, эерэг харилцаа хандлагыг эрхэмлэн, манлайлж ажиллана.
- Бүтээлч, санаачилгатай. Үйл ажиллагаандаа шинжлэх ухааны нотолгоо, үндэслэлтэй хандаж, ажилтан бүр шинэ техник, технологи, инновацыг нэвтрүүлэгч, санаачлагч, суралцагч, бүтээлч байна.
- Мэргэшсэн, мэдлэг, чадвартай. Ажил үүргээ мэргэжлийн түвшинд мэдлэг, чадварт тулгуурлан гүйцэтгэж, үр дүнг эрхэмлэн ажиллана.
- Шударга, ил тод, тэгш. Алхам бүрд хууль тогтоомжийг мөрдөж, шударга, ил тод, шуурхай, тэгш байдлыг хангаж ажиллана.

АЛСЫН ХАРАА

Нийслэлийн жишиг тосгоны эрүүл мэндийн төв болох

ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай тасралтгүй хүргэж иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал мэдлэгтэй иргэдийн тоог нэмэгдүүлж хорооны иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилт 1. Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулна.

Зорилт 2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна.

Зорилт 3. Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэн, нийгмийн баталгааг хангана.

Зорилт 4. Байгууллагын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг оновчтой, үр дүнтэй болгоно.

Зорилт 5. Байгууллагын мэдээллийн тогтолцоог цахимжуулах ажлыг хөгжүүлж, новолгоонд суурилсан мэдээ, мэдээллийг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана.

Зорилт 6. Байгууллагын тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

- T-** Төрийн үйлчилгээний албан хаагчийн өндөр ёс зүйтэй ажиллах.
- T-** Түмний сэтгэлд хүрч ажиллах.
- Э-** Энэрэнгүй хүнлэг сэтгэлээр үйлчлүүлэгчдэдээ хандах.
- M-** Мэргэжлийн өндөр мэдлэг, үр чадвартай байх.
- T-** Түргэн шуурхай, чанартай үйлчилгээг иргэдэд үзүүлэх

Хариуцлага, ёс зүйтэй. Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлагаа дээдлэн, ёс зүй, эерэг харилцаа хандлагыг эрхэмлэн, манлайлж ажиллана.

Бүтээлч, санаачилгатай. Үйл ажиллагаандаа шинжлэх ухааны нотолгоо, үндэслэлтэй хандаж, ажилтан бүр шинэ техник, технологийг нэвтрүүлэгч, суралцагч, бүтээлч байна.

Мэргэшсэн, мэдлэг чадвартай. Ажил үүргээ мэргэжлийн түвшинд мэдлэг, чадварт тулгуурлан гүйцэтгэж, үр дүнг эрхэмлэн ажиллана.

Шударга, ил тод, тэгш. Алхам бүрд хууль тогтоомжийг мөрдөж, шударга, ил тод, шуурхай, тэгш байдлыг хангаж ажиллана.

ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтод түвшин				Хэрэгжүүлэгч байгууллага	Хамтрагч байгууллага
						2025 он	2026 он	2027 он	2028 он		
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулна.											
Зорилт -1 Нийгмийн эрүүл мэндийн мэдээ мэдээлэл сургалт сурталчилгааг танхим болон цахим хэлбэрээр явуулах	Арга хэмжээ-1 Халдварт болон халдварт бус өвчний талаарх сургалтыг сургууль болон цэцэрлэгийн хүүхдүүд асран хамгаалагч нарт сургалт орох	Нийт сургалт зохион байгуулсан тоо	тоо	2024	3	4	5	6	7	ТТЭМТ	26,165 сургууль, 144,313 цэцэрлэг
	Арга хэмжээ-2 Туул тосгоны эрүүл мэндийн эмч эмнэлгийн мэргэжилтэнүүдэд дотоодын сургалт зохион байгуулах	Нийт сургалт зохион байгуулсан тоо	тоо	2024	2	4	5	5	5	ТТЭМТ	Эм ханган нийлүүлэх байгууллагууд
	Арга хэмжээ-3 Нийгмийн эрүүл мэндийн	Нийт сургалт зохион байгуулсан тоо	тоо	2024	1	2	4	4	5	ТТЭМТ	НЭМГ, бусад байгууллагууд

	сургалтуудыг тосгоны харьяа байгууллагуудтай хамтран зохион байгуулах											
Зорилт-2 Халдварт бус өвчин эмгэг тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, эмчлэх, хяналтын тогтолцоог сайжруулах	Арга хэмжээ-1 Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийг тогтмол зохион байгуулах	Хамрагдалтын түвшин	хувь	2024	-	20	25	30	35	ТТЭМТ	НЭМГ, бусад байгууллагууд	
	Арга хэмжээ-2 “Эрүүл шүд” арга хэмжээг зохион байгуулах /2-16 насны хүүхдүүдэд/	Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан хүүхэд	хувь	2024	80	82	83	84	85	ТТЭМТ	26,165 сургууль, 144,313 цэцэрлэг	
Зорилт -3 Хүрээлэн буй орчноос үүдэлтэй өвчин эмгэг сэтгэц зан үйлийг тандах, өвлөлөөс урьдчилан сэргийлэх,	Арга хэмжээ-1 Зонхилон тохиолдох халдварт бус өвчний шалтгаан, эрсдэлт зан үйлийг бууруулах чиглэлээр нөлөөллийн ажлыг тасралтгүй зохион байгуулах (осол гэмтэл, таргалалт, даралт ихсэлт г.м)	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2024	1	2	3	4	5	ТТЭМТ	Тосгоны харьяа байгууллагууд	
		Боловсруулсан контент	тоо	2024	-	1	1	1	1	ТТЭМТ	Тосгоны харьяа байгууллагууд	

эрүүл мэндийн боловсрол олгох	Арга хэмжээ-2 Сурагч, залуучуудад хорт зуршил, түүний хор хөнөөлийн талаар сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулах	ЕБС-ийн сурагчдын дунд тамхигүй хамт олон аянд хамрагдсан ахлах ангийн сурагчид	тоо	2024	20	100	120	140	160	ТТЭМТ	26,165 сургууль, тосгоны залуус
	Арга хэмжээ-3 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, тэдэнд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2024	-	1	1	1	1	ТТЭМТ	НЭМГ, Бусад байгууллагууд
Зорилт -4 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах тогтолцоог	Арга хэмжээ-1 БЗДХ, ХДХВ, гепатит, сүрьеэ өвчний эрт илрүүлэлт, хавьтлын тандалт судалгааг нэмэгдүүлж, хянах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах	4000 хүн амд БЗДХ-ын өвчлөл	промилль	2024	44.3	40.0	38.0	35.0	34.0	ТТЭМТ	ЭМЯ, НЭМГ, ХӨСҮТ
		4000 хүн амд гепатитын өвчлөл	промилль	2024	0.9	0.88	0.85	0.83	0.82		
		Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (4000 хүнд ногдох тухайн жилд сүрьеэгээр өвчилсөн хүний тоо)	просант имиль	2024	12.0	11.0	10.0	9.0	8.0		
	Арга хэмжээ-2 Товлолт дархлаажуулалтын	Товлолт дархлаажуулалтын хамрагдалтын түвшин	хувь	2024	95	96	96	97	97	ТТЭМТ	ЭМЯ, НЭМГ, ХӨСҮТ

бүрдүүлж чадавхжуулах	хамрагалтыг нэмэгдүүлэх											
	Арга хэмжээ-3 Томуугийн дархлаажуулалтад хамрагдах зорилтот хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	Томуугийн дархлаажуулалтад хамрагдсан зорилтот хүн ам	хувь	2024	99	99	99	100	100	ТТЭМТ	ЭМЯ, НЭМГ, ХӨСҮТ	
Зорилт -5 Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн эмэгтэйчүүдэд чиглэсэн гэр бүл төлөвлөлтийн боловсрол олгох, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Арга хэмжээ-1 Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг нэмэгдүүлэх, хамруулах	ЖСАХ-ээр хангагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд	тоо	2024	15	20	25	30	35	ТТЭМТ	Тосгоны нөхөн үржихүйн эмэгтэйчүүд	
	Арга хэмжээ-2 Өсвөр үеийнхний дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	тоо	2024	2	3	3	4	4	ТТЭМТ	26-р сургууль	
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна.												

Зорилт- 1 Эмнэлгийн тусламж үйлчилгээг тосгоны хүн амын эрэлт, хэрэгцээтэй уялдуулан шинэчлэн зохион байгуулах,	Арга хэмжээ-1 Нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчээр хангах	Хүүхдийн эмчийг сургаж бус нутагт тогтвор суушилтай ажиллуулах	тоо	2024	0	0	0	1	1	ТТЭМТ	НЭМГ, НХБХСГ, ХЭМБ
	Арга хэмжээ-2 Эмчилгээ үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээг нэвтрүүлэх	тоо	2024	-	-	-	1	-	ТТЭМТ	НЭМГ, ЭМДЕГ
		Уламжлалт анагаах ухааны хэвтэн эмчлүүлэх ортой болох	тоо	2024	-	-	-	3	-		
	Арга хэмжээ-4 Нярайн шарлалтыг анхан шатанд эмчлэх, бууруулах. Эрсдэл хүндрэлээс сэргийлэх.	Нярайн шарлалтын 360° ФОТО АППАРАТ хангах	тоо	2024	-	-	-	-	1	ТТЭМТ	НЭМГ, ЭМЯ, НЗДТГ,
	Арга хэмжээ-5 AI-д суурилсан оношлогоонуудыг нэвтрүүлэх	AI-д суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг хийх тоног төхөөрөмжтэй болох	тоо	2024	-	-	-	-	1	ТТЭМТ	НЭМГ, ЭМЯ, Дүүргийн ЗДТГ
		AI-д суурилсан зүрх судасны эрсдэлийг эрт илрүүлэх	тоо	2024	-	-	1	-	-	ТТЭМТ	

		төхөөрөмжтэй болох										
	Арга хэмжээ-6 Зонхилон тохиолдох хавдарын оношлогоо, урьдчлан сэргийлэх үзлэгт 30 дээш насны иргэдийг бүрэн хамруулах	Хавдрын түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх	тоо	2024	-	100	120	140	160	ТТЭМТ	НЭМГ	
Зорилт-2 Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Арга хэмжээ-1 Эхийн эндэгдэл бууруулах	Эхийн эндэгдлийн харьцаа (100 амьд төрөлтөд ногдох)	просант имиль	2024	-	0	0	0	0	ТТЭМТ	ЭНЭҮТ - 2	
	Арга хэмжээ-2 Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүд	хувь	2024	75	80	80	80	80	ТТЭМТ	НЭМГ, ЭНЭҮТ - 2	
Зорилт-3 Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх	Арга хэмжээ-1 ЭМТҮЧАБ-н 6 сарын сургалтанд ажилтанг хамруулж мэргэшүүлэх	Зохион байгуулсан сургалт	тоо	2024	-	-	1	-	-	ТТЭМТ	ЭМХТ ЭХЭМҮТ	
	Арга хэмжээ-2 ЭМТҮЧАБ-н талаарх гадаад сургалтыг жил бүр ажлын байран дээр авах	Зохион байгуулсан сургалт	тоо	2024	-	1	1	2	2	ТТЭМТ	Эрүүл мэндийн чанарын холбоо	

	Арга хэмжээ-2 ISO олон улсын стандартыг нэвтрүүлэх	ОУ-ын стандарт нэвтрүүлсэн байгууллага	тоо	2024	-	-	1	-	-	ТТЭМТ	Эрүүл мэндийн чанарын холбоо
	Арга хэмжээ-3 Эрүүл мэндийн байгууллагын магадлал итгэмжлэлд орох	Магадлан итгэмжлэл	тоо	2024	1	1	-	-	-	ТЭМТ	НЭМГ, ЭМХТ
Зорилт-4 Эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах	Арга хэмжээ-1 Клиникийн эм зүйн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Клиник эм зүйчийн сургалтад хамрагдах	тоо	2024	-	1	-	-	-	ТТЭМГ	ЭМХТ
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэн, нийгмийн баталгааг хангана.											
Зорилт-1 Байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, чадавхжуулах,	Арга хэмжээ-1 Эмнэлгийн хүний нөөцийн хэрэгцээний судалгаа хийж, шаардлагатай хүний нөөцийг сургах, хангах арга хэмжээг зохион байгуулах	Судалгаа	тоо	2024	-	1	1	1	1	ТТЭМТ	ТТЭМТ
		Судалгааны дүнд үндэслэн хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	хувь	2024	-	-	60	70	80	ТТЭМТ	ЭМЯ, НЗДТГ, ЭМХТ

урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээ-2 Сургалтанд хамрагдах эмч нарын судалгааг гаргах, суралцахад дэмжлэг үзүүлэх	Сургалтад хамрагдсан тоо	тоо	2024	1	1	1	1	1	ТТЭМТ	НЭМГ, ЭМЯ, ЭМХТ, АШУУИС
	Арга хэмжээ-3 Эрүүл мэндийн удирдах ажилтан, менежерүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо	тоо	2024	1	1	1	1	1	ТТЭМТ	НЭМГ
	Арга хэмжээ-4 Эмч, сувилагчийг мэргэжлийн зэрэг хамгаалах шалгалтад хамруулах	Шалгалтад хамрагдсан ажилтны тоо	тоо	2024	1	1	1	1	1	ТТЭМТ	НЭМГ
	Арга хэмжээ-5 Эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлэх	Илтгэлийн тоо	тоо	2024	-	1	1	1	1	ТТЭМТ	НЭМГ
	Арга хэмжээ-6 Ажилтны ур чадварын үнэлгээ хийх, Ажилтны мэдлэг мэргэжлийн ур чадвар, ажлын	Үнэлгээ хийсэн	хувь	2024	-	75	80	85	90	ТТЭМТ	НЭМГ

	гүйцэтгэлд үнэлгээ хийж сургалтын хэрэгцээг тодорхойлох										
	Арга хэмжээ-7 Яаралтай тусламжийн сургалтад хамруулах, яаралтай нөхцөлд ажиллах чадварыг сайжруулах	Сургалтанд хамрагдсан тоо	тоо	2024	1	1	1	1	1	ТТЭМТ	ЭМХТ НЭМГ
Зорилт-2 Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, эрүүл мэндийн ажилтныг ажлын байрны эрсдэлээс хамгаалах	Арга хэмжээ-1 Эрүүл мэндийн ажилтны эрүүл, аюулгүй шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ ний тайлан	хувь	2024	-	70	80	85	90	ТТЭМТ	НЭМГ
		Ажиллагсдын сэтгэл ханамж	Хувь	2024	80	82	84	86	88		
	Арга хэмжээ-2 Эрүүл мэндийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургаж, эрсдэл бууруулах арга хэмжээг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байгууллага, хүн	тоо	2024	-	1	-	1	-	ТТЭМТ	НЭМГ, ЭМАҮЭ Холбоо

	Арга хэмжээ-3 Хамгаалах хэрэгсэл хангах, Ажилтны аюулгүй байдлыг хангах хамгаалах хэрэгслийг бүрэн хангах	Хангасан	хувь	2024	70	80	90	95	100	ТТЭМТ	НЭМГ
Зорилт-3 Эмнэлгийн мэргэжилтний тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах	Арга хэмжээ-1 Нийслэлийн дахин төлөвлөлтийн бүс нутагт баригдаж буй орон сууцанд хамруулах	Орон сууцанд шинээр хамрагдсан эмнэлгийн ажилтан	тоо	2024	-	-	-	1	-	ТТЭМТ	Тосгоны ажлын алба, Төрийн болон ТББ
	Арга хэмжээ-2 Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Боловсруулсан хөтөлбөр	тоо	2024	1	1	1	1	1	ТТЭМТ	
	Арга хэмжээ-3 Спортын арга хэмжээ зохион байгуулах, Ажилтаны биеийн тамир, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих	Арга хэмжээ	тоо	2024	1	1	1	1	1	ТТЭМТ	НЭМГ, бусад эрүүл мэндийн байгууллагууд
	Арга хэмжээ-4	Үзлэгт хамрагдсан ажилтан	хувь	2024	90	90	95	95	95	ТТЭМТ	НЭМГ

	Ажилтны Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах, Ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүл мэндийн хамгаалах											
СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4. Байгууллагын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг оновчтой, үр дүнтэй болгоно.												
Зорилт-1 Эмнэлгийн санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлэх, тогтвортой байдлыг хангах	Арга хэмжээ-1 Санхүүжилтийн эрсдэлийг тооцох, бууруулахад шаардлагатай зохицуулалтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны тайлан	хувь	2024		60	70	90	100	ТТЭМТ	НЭМГ ЭМЯ, ЭМДЕГ	
	Арга хэмжээ-2 Байгууллагын удирдлага, санхүүгийн мэргэжилтнийг тогтмол сургалтад хамруулан чадавхжуулах	Сургалтад хамрагдсан байгууллага	тоо	2024		1	2	3	4	ТТЭМТ	ЭМХТөв, Төрийн болон ТББ НЭМГ ЭМЯ,	
		Сургалтад хамрагдсан хүн	тоо	2024		2	2	2	2			

Зорилт-2 Эрүүл мэндийн төвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг хийж, нөөцийг оновчтой, үр дүнтэй хуваарилах замаар барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, автомашины хангамжийг стандартын шаардлагад нийцүүлэн үе шаттай хүргэх	Арга хэмжээ-1 Эрүүл мэндийн төвийн хөрөнгө оруулалтын дараа оны нэгдсэн төлөвлөлтийг боловсруулан оновчтой, үр дүнтэй хуваарилах	Гүйцэтгэлийн биелэлт	хувь	2024		100	100	100	100	ТТЭМТ	НЭМГ ЭМЯ НӨХГ
	Арга хэмжээ-2 Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашин авах, ашиглагдахгүй автомашиныг актлах	Нийлүүлэх зориулалтын машин	тоо	2024		1	2	1	1	ТТЭМТ	
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5. Байгууллагын мэдээллийн тогтолцоог цахимжуулах ажлыг хөгжүүлж, новолгоонд суурилсан мэдээ, мэдээллийг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана. ашиглана.											
Зорилт-1 Орчин үеийн технологийн шийдэлд тулгуурлан	Арга хэмжээ-1 Өгөгдөлд суурилсан эрүүл мэндийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх	Цахим хяналтын системийн гүйцэтгэл, хөгжүүлэлт	тоо	2024	-	-	1	-	-	ТТЭМТ	НЭМГ

эрүүл мэндийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, иргэн төвтэй цахим үйлчилгээг чанаржуулан хөгжүүлэх	(Цахим Dashboard-г бий болгох)											
	Арга хэмжээ-2 Цахим бүртгэлтэй болох	Цахим бүртгэл ашиглалтад оруулах	тоо	2024	-	1	-	-	-	ТТЭМТ	НЭМГ	
	Арга хэмжээ-3 Байгууллагын вэб сайтын хөгжүүлэлтийг сайжруулах	Программ хөгжүүлэлт	хувь	2024	80	80	90	95	100	ТТЭМТ	НЭМГ	
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 6. Байгууллагын тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.												
Зорилт-1. Зорилго алсын хараа, стратегийг сайжруулах	Арга хэмжээ-1 Байгууллагын стратеги, алсын харааны талаарх ажилтнуудын ойлголт, мэдлэгийн түвшинг үнэлэх	Үнэлгээ	Хувь		-	-	50	70	80	ТТЭМТ	НЭМГ	
	Арга хэмжээ-2 Байгууллагын тасаг, нэгжүүдийн жилийн төлөвлөгөөний үнэлгээ хийнэ	Үнэлгээ	Хувь	2024	-	-	70	80	90	ТТЭМТ	НЭМГ	
Зорилт-2. Байгууллагын соёл ба манлайллыг хэрэгжүүлэх	Арга хэмжээ-1 Хамт олны дунд эерэг хандлага, инноваци соёлын төлөвшүүлнэ	Ажилтнуудын санаачилан хэрэгжүүлсэн шинэ санаа, сайн туршлага	Тоо	2024	-	1	1	2	2	ТТЭМТ	НЭМГ	

	Арга хэмжээ-2 Байгууллагын дотоод журам, хамтын хэлэлцээрийг шинэчилнэ.	Шинэчилсэн журам, хэлэлцээр	Тоо	2024	1	-	2	-	2	ТТЭМТ	НЭМГ
--	---	--------------------------------	-----	------	---	---	---	---	---	-------	------